

MONEUL төслийн талаар болон хэрхэн оролцож болох талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу.

Брюсселийн Их Сургууль
(Хуулийн Тэнхим болон Багш
Боловсролын Хүрээлэн)

Тэтгэлэг эзэмшигч: Грасиен Лауверс
(Жон Моне Профессор, Ph.D.)

✉ Gracienne.lauwers@vub.be

🌐 Website: <https://moneul.eu>

📺 Youtube сувар: EduLaw
<https://www.youtube.com/@edulaweu>

Энэхүү төсөл нь Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж байна. Тус товхимолын агуулгыг зөвхөн зохиогчид хариуцах бөгөөд ямар ч тохиолдолд Европын Холбооны үзэл бодлыг тусгаагүй болно.



<https://www.facebook.com/khovdmoneul>

MONEUL төсөл нь Монголын түнш их дээд сургуулиудын Нийгмийн ухаан, Хэл, Багш бэлтгэх тэнхимүүдэд Европын Холбооны талаарх хүртээмжтэй дижитал сургалтыг дэмжих зорилготой. MONEUL нь нэг улсын олон талт түншлэлийн хувьд Бельги, Польш, 5-р бүсийн (Ази) Монгол улсын болон Европын Холбооны түнш их сургуулиудыг нэгтгэдэг.



ЕВРОПЫН ХОЛБОО СУДЛАЛ
ДИЖИТАЛ ХҮРТЭЭМЖТЭЙ
СУРАЛЦАХУЙН ЗАГВАР





MONEUL -ын тухай

MONEUL төсөл нь Европын Холбооны тухай дижитал сургалтын модулиудыг багтаасан Монголын боловсролын зарим хөтөлбөрүүдийг баяжуулах зорилготой хамтын хүчин чармайлт юм. Бельги, Польш, Монгол улсын их дээд сургуулиудын хамтын ажиллагааны хүрээнд MONEUL нь оюутнууд, багш нарын ЕХ-ны ардчилсан бүтэц, үнэт зүйл, бодлогын талаарх ойлголт, үнэлэмжийг нэмэгдүүлэхийг эрмэлзэж байна.



Төслийн зорилго

- Европын Холбооны тухай дижитал сургалт, заах аргачлалыг хэрэгжүүлэх Монголын түнш их дээд сургуулиудын чадавхийг бэхжүүлэх
- ЕХ-той холбоотой агуулгыг баяжуулахын тулд одоо байгаа хөтөлбөрүүд болон заавал судлах хичээлүүдийг шинэчлэх
- ЕХ-ны засаглал, соёл, түүхийн янз бүрийн асуудлыг хөндсөн шинэ онлайн модулиудыг бий болгох
- Суралцахуйг дэмжих зорилгоор ЕХ-ны нэр томъёоны Монгол-Англи толь бичгийг боловсруулах
- Их, дээд сургуулийн номын сангуудын ЕХ-ны судалгааны эх сурвалжуудыг нэмэгдүүлэх, шинэчлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тэгш хамруулсан суралцахуйн загвар бүхий болгох
- Боловсролын санаачилга, соёлын солилцооны хөтөлбөрөөр дамжуулан ЕХ-ны Монгол дахь харагдацыг нэмэгдүүлэх



Бидэнтэй нэгдээрэй

Хүртээмжтэй дижитал боловсрол, ЕХ-Монголын соёлын солилцоог ахиулахад хувь нэмрээ оруулж, Монгол Улс, Европын Холбооны харилцан ойлголцол, хамтын ажиллагааны гүүрийг бий болгоход хувь нэмрээ оруулах энэхүү өөрчлөлтийн аянд бидэнтэй нэгдээрэй.

Бидний боловсруулсан хичээлүүд

Бага боловсрол



Дунд, ахлах боловсрол



Дээд боловсрол

